



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
СУРГАЛТ, ҮНЭЛГЭЭ, СУДАЛГААНЫ  
ИНСТИТУТ

# АЛБАН БАЙГУУЛЛАГА /ОФФИС/-ЫН ҮЙЛЧЛЭГЧИЙН АЖЛЫН АЧААЛЛЫГ ТООЦОХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

*Албан хэрэгцээнд*

Улаанбаатар хот

2023 он

# ГАРЧИГ

Хүснэгтийн жагсаалт .....	3
Зургийн жагсаалт .....	3
Товчилсон үгийн жагсаалт .....	4
УДИРТГАЛ.....	5
БҮЛЭГ НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....	6
1.1 Танилцуулга .....	6
1.2 Судалгааны арга зүй.....	7
БҮЛЭГ ХОЁР. АЛБАН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧЛЭГЧ /ЦЭВЭРЛЭГЧ/-ИЙН АЖЛЫН АЧААЛАЛ.....	9
2.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл .....	9
2.2 Үйлчлэгчийн ажлын ачааллын ерөнхий төлөв байдал .....	11
2.3 Үйлчлэгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйл .....	13
2.4 Үйлчлэгчийн ажилд зарцуулж буй хугацаа .....	15
БҮЛЭГ ГУРАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ .....	24

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. 2001 оны “Нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбай, ажлын үлгэрчилсэн хэмжээ” .....	6
Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан үйлчлэгчдийн тоо, цалингийн бүлгээр, эзлэх хувь .....	11
Хүснэгт 3. Үндсэн үйлчлэгчийн тоо болон одоо ажиллаж байгаа үйлчлэгчийн тоо, зөрүү .....	11
Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан байгууллагуудын ерөнхий мэдээлэл .....	14
Хүснэгт 5. Нэг өрөөний цэвэрлэгээнд зарцуулж байгаа дундаж хугацаа, ажилбарын ерөнхий ангиллаар, тухайн ажилбарт ажилласан үйлчлэгчдийн тоо .....	14
Хүснэгт 6. Нэг өрөөний цэвэрлэгээнд зарцуулж байгаа дундаж хугацаа, ажилбарын ерөнхий ангиллаар, тухайн ажилбарт ажилласан үйлчлэгчдийн тоо .....	15

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. 2023 оны цэвэрлэгч /үйлчлэгч/, ажил мэргэжлийн эрэлт .....	6
Зураг 2. Судалгаанд хамрагдсан үйлчлэгч, байршлаар .....	9
Зураг 3. Судалгаанд хамрагдсан үйлчлэгч, насны ангилалаар .....	10
Зураг 4. Судалгаанд хамрагдсан үйлчлэгчдийн ажилласан жил, ажлын цаг, бүтцээр .....	10
Зураг 5. Цэвэрлэгээний тоног төхөөрөмжөөр хэр хангагдсан вэ? .....	12
Зураг 6. НХХЯ-ны Сайдын 2001оны "Нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбай, ажлын үлгэрчилсэн хэмжээ" 03 тоот тушаалаар батлагдсан журам шинэчлэгдээгүй талаар та ямар бодолтой байгааг тодруулахад .....	12
Зураг 7. Байгууллагадаа ажлын байрны норм, норматив болон стандарттай эсэх, үйлчлэгчийн ажлын ачааллыг тооцдог эсэх, хувиар .....	13
Зураг 8. Бэлтгэл ажилд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, минут .....	16
Зураг 9. Цэвэрлэгээг эхлэх, агааржуулалт хийхэд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр .....	16
Зураг 10. Цэцэг арчилгаанд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр .....	17
Зураг 11. Ширээ /систем тавилга/, компьютерийн цэвэрлэгээнд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр .....	17
Зураг 12. Сейф, шүүгээ, номын тавиур, зураг, сувинерын цэвэрлэгээ, төрөл, хувиар .....	18
Зураг 13. Сейф, шүүгээ, номын тавиур, зураг, сувинерын цэвэрлэгээнд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр .....	18
Зураг 14. Шилэн гадаргуутай эд зүйлсийн цэвэрлэгээнд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр .....	19
Зураг 15. Хог шүүрдэх, тоос соруулах цэвэрлэгээнд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр .....	20
Зураг 16. Шал угаах ажилбарт зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр .....	20

Зураг 17. Хивс цэвэрлэгээ хийхэд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр.....	21
Зураг 18. Ариун цэврийн өрөөний тоо, нэг үйлчлэгчид ноогдох дундаж, хэрэгсэлээр .....	21
Зураг 19. Ариун цэврийн өрөө цэвэрлээнд зарцуулсан дундаж хугацаа, ажилбар, секундээр	22
Зураг 20. Гадна талбайн цэвэрлээнд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр...	23
Зураг 21. Коридор, шатны тоо, цэвэрлэх талбай, дундаж хугацаагаар.....	23

## **ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

ХНХСҮСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ, судалгааны институт
ҮАМАТ	Олон улсын Ажил, мэргэжлийн Стандарт Ангилал (ISCO-08)
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам /хуучин нэршлээр/

## УДИРТГАЛ

Монгол Улс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын суурь найман конвенцод нэгдэн орж, соёрхон баталсан үеэс эхлэн олон улсын өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу хүн амын хөгжил, хөдөлмөр, нийгмийн хамгааллын харилцан хамаарал бүхий цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангахад бодлогын чиглэлээр шат дараатай олон ажлуудыг хийж, хэрэгжүүлж ирсэн.

Үндэсний статистикийн хорооны 2022 оны “Ажиллах хүчний судалгаа”-гаар хөдөлмөрийн насны хүн ам 2,159,568 мянга, үүнээс 1,265,210 мянга нь ажиллах хүч, 894,358 мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Нийт ажиллах хүчний 678,756 нь эрэгтэйчүүд, 586,455 нь эмэгтэйчүүд байна.

Улсын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 246,361 мянган аж ахуй нэгжээс үйл ажиллагаа явуулж буй 86,356 аж ахуй нэгж байгууллагын 1-9 ажилтантай 72,600, 10-19 ажилтантай 6,349, 20-49 ажилтантай 4,851, 50 дээш ажилтантай 2,556 байгууллагад 1,180,474 мянган ажиллагчид байна. Үүнээс Энгийн ажил, мэргэжил <sup>1</sup>110,759 мянга байна. /эх сурвалж Үндэсний статистикийн хороо/

Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос “Хөдөлмөрийн норм, норматив боловсруулах аргачлал”-ыг батлан гаргадаг бөгөөд хамгийн сүүлд 2022 оны 3 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан.

Манай улсад сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд үйлчлэгчийн ажлын ачааллыг тооцож, норм нормативыг шинэчлэн боловсруулах чиглэлээр тухайлсан судалгаа хийгдээгүй. “Нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбай, ажлын үлгэрчилсэн хэмжээ” 2001 оноос хойш шинэчлэгдээгүй бөгөөд Ажиллах хүчний эрэлт хэрэгцээг тодорхойлох Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаагаар сүүлийн 3 жил дараалан аж ахуй нэгж, байгууллагуудад үйлчлэгч дутагдалтай, үйлчлэгчийн эрэлт хэрэгцээ өндөр гарсан.

Иймд албан байгууллага /оффис/-ийн цэвэрлэгч /үйлчлэгч/-ийн ажлын ачааллыг тооцож, хөдөлмөр зарцуулалтын хэмжээг тогтоон, давхар нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлэх нь үйлчлэгчийн хөдөлмөрийн норм, нормативыг шинэчлэх, боловсронгуй болгоход үндэс суурь болох чухал ач холбогдолтой юм.

---

<sup>1</sup> Өдөр тутмын, байнга давтагдах шинжтэй энгийн ажил, үүргийг гар багаж хэрэгсэл ашиглан гүйцэтгэх бөгөөд голчлон биеийн хүчний ажил эрхэлнэ. (YAMAT)

## БҮЛЭГ НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 1.1 Танилцуулга


Албан байгууллага /оффис/-ын цэвэрлэгч /үйлчлэгч, албан тасалгааны <sup>2</sup>цэвэрлэх талбайн хэмжээ болон цэвэрлэх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 2001 оны 04-р сарын 12-ны өдрийн Монгол улсын засгийн газрын тохируулагч агентлаг, хөдөлмөр, нийгмийн хамгааллын улсын хяналтын албаны даргын 03 тоот тушаалаар “Нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбай, ажлын үлгэрчилсэн хэмжээ” батлагдсан байна. Тус тушаалд нэг үйлчлэгч албан конторт 300-365 м<sup>2</sup>, Үйлдвэрлэл үйлчилгээний газарт 250-315 м<sup>2</sup>, ариун цэврийн өрөөнд 75 м<sup>2</sup> талбай /15-30 суулт, хөтөвч, гар угаагуур оролцуулан/-г цэвэрлэнэ гэж заасан байдаг.

Хүснэгт 1. 2001 оны “Нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбай, ажлын үлгэрчилсэн хэмжээ”

№	Модон шал /мкв/	Дубэн шал /мкв/	Алаг чулуун шал /мкв/	Хулдаасан шал /мкв/	
1	Албан конторт	300-350	350-400	325-375	315-365
2	Үйлдвэрлэл үйлчилгээний газар	250-300	300-350	275-325	260-315
3	Ариун цэврийн өрөө	Нийлбэрээрээ 75м <sup>2</sup> -аас доошгүй талбайтай 15-30 суултуур, хөтөвч, гар угаагуур /почки, унитаз/-тай бие засах газар, гар угаах газар эсвэл суултуур угаагуур, хавтанцар алаг чулуун шал, хана зэргийг оролцуулан 150 м <sup>2</sup> -аас доошгүй талбайд			
4	Хивс, хивсэнцэр	Хивсэнцрээр битүү хучсан шалыг цахилгаан хэрэгслийн тусламжтайгаар цэвэрлэх ажилд 250-300 м <sup>2</sup> талбайд тус тус 1 үйлчлэгч байна.			

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаагаар албан тасалгааны цэвэрлэгч, үйлчлэгч ажил мэргэжлийн ажиллах хүчний эрэлт жил бүр өндөр байх үр дүн гардаг бөгөөд сүүлийн 3 жилийн байдлаар нийт эрэлтийн 2.0-5.0 хувийг бүрдүүлж байна. Үүнээс гадна тухайн ажил мэргэжлийн ажиллах хүчний хомсдолд эзлэх хувь ч өндөр байсаар байна.

Зураг 1. 2023 оны цэвэрлэгч /үйлчлэгч/, ажил мэргэжлийн эрэлт



Эх сурвалж: ХНХСҮСИ

Тухайлбал сүүлийн 3 жилийн нийт ажиллах хүчний хомсдолын 2.0 - 8.0 хувийг албан тасалгааны цэвэрлэгч, үйлчлэгч мэргэжлийн ажиллагчид эзэлж байжээ. Өөрөөр хэлбэл

<sup>2</sup> Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08-д Энгийн ажил мэргэжил ангилал “9112-11 Цэвэрлэгч/үйлчлэгч, албан тасалгааны

эрэлттэй ажил мэргэжил болон хомсдолтой ажил мэргэжлийн жагсаалтад тэргүүлж байгаа нь тус ажлын байрны эрэлтийг харуулж байна.

### **Судалгааны зорилго, зорилт, ач холбогдол**

Судалгааны зорилго нь албан байгууллагын буюу оффисын үйлчлэгч /цэвэрлэгч/ ийн ажлын цаг ашиглалт, хөдөлмөр зарцуулалтын норматив хэмжээг судлан, ажлын ачааллыг тооцоход оршино.

### **Судалгааны зорилт**

- Албан байгууллагын үйлчлэгч /цэвэрлэгч/-ийн ажлын ачааллыг тооцох үзүүлэлтийг тодорхойлох;
- Ажлын дундаж хурд болон 1 үйлчлэгч /цэвэрлэгч/-д ноогдох талбайн хэмжээг тодорхойлох;
- Үйлчлэгчийн үндсэн ажил үүргээс бусад нэмэлт ажлуудыг судалж ажлын ачааллыг тооцох талаар санал, зөвлөмж боловсруулна.

Дээрх зорилго зорилтод хүрэхийн тулд судалгааны багийн зүгээс үйлчлэгч /цэвэрлэгч/-ээс ярилцлага асуулгын арга болон үйлчлэгчийн ажлын байрны зураг авалт, ажиглалт, ажлын байрны тодорхойлолтыг шинжлэх, хүний нөөц болон шууд удирдах албан тушаалтнаас ярилцлага асуумжийг авч, ажлын ачаалалд шууд болон дам байдлаар нөлөөлж буй асуудлуудыг судалсан болно.

### **Сэдвийн судлагдсан байдал**

Монгол улсад оффис /албан тасалгааны/ цэвэрлэгч /үйлчлэгч/-ийн ажил мэргэжлийн чиглэлээр ажлын байрны ачааллыг тооцсон тухайлсан судалгааны тайлан байхгүй, харин ажил мэргэжлийн чиглэлүүдээр судалгааны тайлангууд олон байдаг байна. Иймд Олон улсын үйлчлэгч /цэвэрлэгч/-ийн ажлын ачааллыг тооцох талаар хийгдэж байсан хэд хэдэн судалгааны тайлан, статистик мэдээ, мэдээлэл зэрэг эх сурвалжуудыг судалгааны хүрээнд ашигласан. Тухайлбал ISSA – Олон улсын цэвэрлэгээ үйлчилгээний холбооноос гаргасан “447 Цэвэрлэгээний цагийг тооцох аргачлал судалгаа”, “Вашингтон мужийн цэвэрлэгээний ажлын ачааллын судалгаа” юм.

## **1.2 Судалгааны арга зүй**

### **Хамрах хүрээ**

Судалгааны хувьд YAMAT-08 <sup>3</sup>Энгийн ажил, мэргэжил ангиллын 9112-11 Цэвэрлэгч /үйлчлэгч, албан тасалгааны, 9112-12 Цэвэрлэгч /үйлчлэгч, угаалгын өрөө, бие засах газрын, үйлчлэгчийг сонгож, судалгаанд хамруулсан.

Судалгааны хамрах хүрээг тодорхойлохдоо Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болон Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар, Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар, Ерөнхий боловсролын сургуулийн нийт 29 байгууллагын оффис /албан тасалгаа/, ариун цэврийн өрөөний цэвэрлэгч /үйлчлэгч/ нарыг зорилтот бүлэг болгон авсан, хүний нөөц болон удирдах албан тушаалтныг судалгаанд мэдээлэл цуглуулах хүрээнд хамруулсан.

<sup>3</sup> Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт

Судалгааны ажлын байрны зураглалын хувьд хаягийн хэсэг, хяналтын хэсэг, судалгаанд оролцогчийн мэдээлэл, бэлтгэл ажил, нэмэлт ажил, үндсэн хэсэг- /цэвэрлэгээ үйлчилгээ/- үүдээс бүрдэх бөгөөд, Асуумжийн хувьд судалгаанд оролцогчийн мэдээлэл, үйлчлэгчийн ажлын ачааллын ерөнхий ойлголт, хуульд орсон өөрчлөлт, цаашид авах арга хэмжээ хэсгүүдэд хувааж авч үзсэн.

### **Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт**

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг тоон ба чанарын асуулга, ярилцлагын аргыг, үйлчлэгчийн ажлын ачааллыг тодорхойлохын тулд үйлчлэгчийн ажлын байрны ажиглалтын аргуудыг хослуулан хэрэглэсэн.

Судалгааны мэдээллийг excel программаар нэгтгэн, мэдээлэл боловсруулж, үндсэн үр дүнг нэгтгэхэд stata программыг ашигласан болно.



## БҮЛЭГ ХОЁР. АЛБАН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧЛЭГЧ /ЦЭВЭРЛЭГЧ/-ИЙН АЖЛЫН АЧААЛАЛ

### 2.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл


Судалгаанд Улаанбаатар хотын 6 дүүргийн нийт 29 байгууллагын хүний нөөц болон удирдах албан тушаалтан, 41 цэвэрлэгч /үйлчлэгч/ хамрагдсан. Үүнд:

- Нийтлэг үйлчилгээний газар – Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар, Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар
- Ерөнхий боловсролын сургууль – Нийслэлийн ерөнхий боловсролын 2-р сургууль, 23-р сургууль, 117-р сургууль
- ХНХЯ-ны харьяа агентлаг, байгууллага – Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, /харьяа газрууд/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт

Судалгаанд хамрагдсан байгууллагуудыг хариуцлагын хэлбэрээр авч үзэхэд 17.1 хувь нь төрийн өмчит, 82.9 хувь нь улсын төсөвт байгууллага байна.

Судалгаанд хамрагдсан үйлчлэгчдийн ажлын байрны байршлаар авч үзвэл 7.3 хувь нь Баянгол, 12.2 хувь нь Баянзүрх, 36.6 хувь нь Сүхбаатар, 9.8 хувь нь Сонгинохайрхан, 9.8 хувь нь Хан-Уул, 24.4 хувь нь Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа эрхлэж байна.

Зураг 2. Судалгаанд хамрагдсан үйлчлэгч, байршлаар



Судалгаанд хамрагдсан үйлчлэгч нар бүгд эмэгтэйчүүд байсан. Үйлчлэгч нарыг насны бүлгээр харахад 9.8 хувь нь 25-35 насныхан, 26.8 хувь нь 36-45 насныхан, 51.2 хувь нь 46-55 насныхан, 12.2 хувь нь 56, түүнээс дээш насныхан байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан 2 үйлчлэгч тутмын нэг нь 46-55 насныхан байна. Цэвэрлэгч, үйлчлэгчийн дундаж нас 48.1 байна.

Зураг 3. Судалгаанд хамрагдсан үйлчлэгч, насны ангилалаар




Судалгаанд хамрагдсан үйлчлэгчдийг тухайн байгууллагад ажилласан хугацааг сараар нь авч үзвэл 46.4 хувь нь 1-6 сар, 26.8 хувь нь 7-12 сар, 17.1 хувь нь 13-24 сар, 9.7 хувь нь 25, түүнээс дээш сар ажилласан байна. Судалгааны үр дүнгийн мэдээллээс харахад 10 үйлчлэгч тутмын 7 (73.2 хувь) нь тухайн байгууллагадаа нэг жил хүртэлх хугацаанд ажилласан байгаа анхаарал татахуйц үр дүн юм.

Нийт үйлчлэгчдийн 9,8 хувь нь буюу 10 үйлчлэгч тутмын нэг нь тухайн байгууллагадаа 2 ба түүнээс дээш жил ажилласан байна. Энэ нь үйлчлэгчдийн ажлын байрны хувьд тогтвортой бус байгааг илэрхийлж байна.

Ажлын байрны зураглал хийсэн өдрөөр ажилласан ажлын цагийг авч үзэхэд 2.4 хувь нь 6 цаг, 46.3 хувь нь 8 цагаар ажилласан бол 36.7 хувь нь 9-10 цаг, 14.6 хувь нь 11-12 цаг ажилласан байна. Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д ердийн ажлын өдрийн үргэлжлэл найман цагаас илүүгүй, долоо хоногийн ердийн ажлын цаг 40-өөс илүүгүй байна гэж заасан байдаг боловч судалгаанд хамрагдсан 2 үйлчлэгч тутмын нэг (51.2 хувь) нь өдөрт 1-4 цагаар илүү цагийн ажил гүйцэтгэдэг байна

Зураг 4. Судалгаанд хамрагдсан үйлчлэгчдийн ажилласан жил, ажилласан ажлын цаг, бүтцээр



Судалгаанд хамрагдсан үйлчлэгчдийн сарын үндсэн дундаж цалин 699.5 мянган төгрөг байна. Байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн өмчит байгууллагын үйлчлэгчид дунджаар 956.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйлчлэгчид дунджаар 655.3 мянган төгрөгийн цалинтай ажиллаж байна. Тус судалгааны мэдээлэл цуглуулалт 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн хооронд үргэлжилсэн бөгөөд 06-р сард 2022 оны 12-р сарын 28-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолын дагуу судалгаанд оролцогчдоос үндсэн цалинг асуусан. Тухайн үед үйлчлэгчдийн үндсэн цалин ТҮ-1 565277 төгрөг байсан. Харин 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дугаар тогтоол батлагдаж, 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн бөгөөд 8, 9-р сард үндсэн

цалинг тус тогтоолын дагуу асуусан. Үүнтэй холбоотойгоор судалгаанд хамрагдсан үйлчлэгчдийн үндсэн цалингийн дунджид өөрчлөлттэй гарсан байна.

Үндэсний статистикийн хорооноос 2022 оны жилийн эцсийн мэдээгээр эмэгтэйчүүдийн дундаж цалин 1360.5 мянган төгрөг байна. Судалгаанд хамрагдсан үйлчлэгчдийн дундаж цалинг ҮСХ-ны үндсэн цалингийн дунжаар харьцуулж үзэхэд нэлээд зөрүүтэй харагдаж байна

Цалингийн бүлгээр авч үзвэл 34.1 хувь нь 550.0-599.0 мянган төгрөг, 48.8 хувь нь 600.0-750.0 мянган төгрөг, 9.8 хувь нь 751.0-950.0 мянган төгрөг, 7.3 хувь нь 951.0-1500.0 мянган төгрөгийн цалин авч байна.

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан үйлчлэгчдийн тоо, цалингийн бүлгээр, эзлэх хувь

Цалингийн бүлэг	Нийт үйлчлэгч		Төрийн өмчит		Улсын төсөвт	
	Нийт	Эзлэх хувь	Нийт	Эзлэх хувь	Нийт	Эзлэх хувь
Нийт	41	100.0	7	100.0	34	100.0
550,000-599,000	14	34.1	0	0.0	14	41.20
600,000-750,000	20	48.8	4	57.1	16	47.10
751,000-950,000	4	9.8	1	14.3	3	8.80
951,000-с дээш	3	7.3	2	28.6	1	2.90

*Хүний нөөц, удирдах албан тушаалтантай хийсэн ярилцлагаас:*

*Үйлчлэгчийн цалин бага учир нийгмийн баталгаа муу, байр орон сууцны хөтөлбөрт хамрагддаггүй. Цалин нэмэх, бүр боломжгүй бол ажлын цагийг богиносгох, хувиараа өөр санхүүгийн эх үүсвэрийг дэмжих зүйтэй байна.*

## 2.2 Үйлчлэгчийн ажлын ачааллын ерөнхий төлөв байдал

Судалгаанд хамрагдсан 29 байгууллага нийтдээ үйлчлэгчийн 182 үндсэн орон тоотой хэдий ч одоогоор 129 (70.9 хувь) үйлчлэгч ажиллаж байна. Үйлчлэгчийн сул орон тоо (29.1 хувь) их байгаа нь бусад үйлчлэгч, цэвэрлэгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байна. Энэ нь албан тасалгааны цэвэрлэгч, үйлчлэгч ажил мэргэжлийн хөдөлмөр эрхлэгчдийг тогтвор суурьшилтай ажиллаж чадахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Судалгаанд хамрагдсан 4 байгууллага тутмын нэг (27.6 хувь) нь сул орон тоотой байна. Зарим байгууллагын хувьд 50 үйлчлэгчийн орон тоотой хэдий ч судалгааны мэдээлэл цуглуулах үер 13 үйлчлэгчтэй ажиллаж байсан. Өөрөөр хэлбэл 4 үйлчлэгчийн ажлыг нэг үйлчлэгч хийж байгаа юм.

Хүснэгт 3. Үндсэн үйлчлэгчийн тоо болон одоо ажиллаж байгаа үйлчлэгчийн тоо, зөрүү

Үйлчлэгчийн тооны бүлгээр	Үндсэн үйлчлэгч	Одоо ажиллаж байгаа үйлчлэгч	Зөрүү
Нийт үйлчлэгчийн тоо	182	129	53
1-2 үйлчлэгч	16	16	0
3-5 үйлчлэгч	3	5	-2
6-10 үйлчлэгч	4	4	0
11, түүнээс дээш	6	4	2

Судалгаанд нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбайн хэмжээг хэрхэн тооцож байгааг тодруулахад 44.8 хувь нь 2001 оны 04-р сарын 12-ны өдрийн Монгол улсын засгийн газрын тохируулагч агентлаг, хөдөлмөр, нийгмийн хамгааллын улсын хяналтын албаны даргын дугаар 3 тушаалаар тооцдог, 34.5 хувь нь тооцдоггүй, 20.7 хувь нь батлагдсан орон тооны бүтцээр ажилладаг гэж хариулсан байна.

Зураг 5. Танай байгууллага нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбайн хэмжээг хэрхэн тооцдог вэ?




Судалгаанд хамрагдсан байгууллагуудын албан тасалгааны цэвэрлэгч, үйлчлэгчдийн цэвэрлэгээний тоног төхөөрөмжөөр хэрхэн хангаж буй талаар асууж тодруулахад 55.2 хувь нь сэгсрэгчтэй шал угаагчтай, 3.4 хувь нь сэгсрэгчтэй шал угаагч, тоос сорогчтой, 20.7 хувь нь шалны модон угаагч, 20.7 хувь нь орчин үеийн тоног төхөөрөмж ашигладаг гэж хариулжээ.

Зураг 6. Цэвэрлэгээний тоног төхөөрөмжөөр хэр хангагдсан вэ?




Судалгаанд хамрагдсан байгууллагуудаас Монгол улсын засгийн газрын тохируулагч агентлаг, хөдөлмөр, нийгмийн хамгааллын улсын хяналтын албаны даргын "Нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбай, ажлын үлгэрчилсэн хэмжээ" 03 тоот тушаалаар батлагдсан журам шинэчлэгдээгүй талаар та ямар бодолтой байгааг асууж тодруулахад 55.2 хувь нь шинэчлэх шаардлагатай, 3.4 хувь нь манай байгууллага норм нормативтай, 37.9 хувь нь батлагдсан орон тоогоор стандартад нийцүүлэн ажиллуулах боломж байдаггүй, 3.4 хувь нь сайн мэдэхгүй байна гэж хариулсан байна.

Зураг 7. НХХЯ-ны Сайдын 2001оны "Нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбай, ажлын үлгэрчилсэн хэмжээ" 03 тоот тушаалаар батлагдсан журам шинэчлэгдээгүй талаар та ямар бодолтой байгааг тодруулахад



Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Хөдөлмөрийн норм, норматив боловсруулах аргачлал” батлагдсан. Гэвч судалгаанд хамрагдсан байгууллагуудын 65.5 хувь нь байгууллагад ажлын байрны норм, норматив байхгүй, 69.0 хувь нь үйлчлэгч/цэвэрлэгч/-ийн ажлын байрны ачааллыг тооцож байгаагүй, 62.1 хувь нь үйлчлэгчийн ажлын байрны стандартгүй гэж хариулсан байна. Тухайн тоон мэдээллээс харахад аж ахуйн нэгж байгууллагууд үйлчлэгчийн норм, норматив, ажлын байрны ачааллын талаар мэдээлэлгүй байгаа нь харагдаж байна. Иймд нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбай, ажлын үлгэрчилсэн хэмжээг зайлшгүй шинэчилж, стандартыг мөрдүүлэх шаардлагатай болсныг харуулж байна.

Зураг 8. Байгууллагадаа ажлын байрны норм, норматив болон стандарттай эсэх, үйлчлэгчийн ажлын ачааллыг тооцдог эсэх, хувиар



Судалгаанд хамрагдсан байгууллагуудын үйлчлэгчдийн ачаалал хэр байдаг талаар асууж тодруулахад 58.6 хувь нь ачаалал их, улирлын чанартай нэмэгддэг, 27.6 хувь нь хэвийн, 13.8 хувь нь ачаалал бага гэж хариулсан байна.

*Албан тасалгааны цэвэрлэгч, үйлчлэгчтэй хийсэн ярилцлагаас:*

*Шинэ буюу орчин үеийн барилгын цонх том, арчиж цэвэрлэхэд хүндрэлтэй унах эрсдэлтэй байдаг. Мөн зөвхөн м<sup>2</sup>.аар тооцдог нь бусад тоног төхөөрөмж, эд хогшлыг оруулаагүйгээс ажлын ачаалал нэмэгддэг. Нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбайн хэмжээг Эд хогшлын тоо, үйлчлүүлж буй иргэдийн тоогоор тооцдог болох гэжээ*

### 2.3 Үйлчлэгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйл

Судалгаанд хамрагдсан байгууллагын 41 үйлчлэгч нь ажлын байрны зураглал хийх үед нийт 321 ажлын өрөө буюу 17392 м<sup>2</sup> талбай, 150 ариун цэврийн өрөө буюу 969 м<sup>2</sup> талбай цэвэрлэсэн байна. Судалгаанд хамрагдсан байгууллагуудын ажлын нэг өрөө нь дунджаар 54.2 м<sup>2</sup>, ариун цэврийн өрөө нь 6.5 м<sup>2</sup> байна. Мөн нэг үйлчлэгч өдөрт дунджаар 424.2 м<sup>2</sup> ажлын өрөөг, 26.2 м<sup>2</sup> ариун цэврийн өрөөг цэвэрлэдэг байна.

Харин судалгаанд хамрагдсан үйлчлэгчдийн 90.8 хувь нь ажлын өрөө болон ариун цэврийн өрөөг хамтад нь цэвэрлэдэг бол 9.2 хувь нь зөвхөн ариун цэврийн өрөө цэвэрлэж байна. Судалгаанд хамрагдсан нэг үйлчлэгчид дунджаар 9 ажлын өрөө, 5 ариун цэврийн өрөө ноогдож байна. Зөвхөн ариун цэврийн өрөөний цэвэрлэгээг хийдэг үйлчлэгчид дунджаар 7 өрөө ноогдож байна.

Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан байгууллагуудын ерөнхий мэдээлэл

Үзүүлэлт	Хэмжих нэгж тоо	Үйлчлэгч	Дундаж үзүүлэлт			
			Талбайн хэмжээ, м <sup>2</sup>		Нэг үйлчлэгчид ноогдох	
			Нийт	Нэг өрөө	Талбайн хэмжээ	Нэг өрөө
Оффисын тоо	29	41	1079790.58	37234.2	26336.4	
Нийт өрөө	321	37	17392.06	54.2	424.2	9
Ариун цэврийн өрөө	150	28	969.56	6.5	26.2	5
Давхарын тоо, дундаж утга	3		440.1	146.7	10.7	

Судалгаанд хамрагдсан үйлчлэгчид нэг өрөөг дунджаар 2611.3 секунд буюу 43.5 минут цэвэрлэж байна. Хамгийн их хугацаа зарцуулж байгаа ажилбарын ангиллаар дундаж хугацааг авч үзвэл коридорын цэвэрлэгээг 53.5 минут, лифтний цэвэрлэгээг 52.0 минут, шатны цэвэрлэгээ 28.2 минут, гадна цэвэрлэгээг 20.9 минут, ариун цэврийн өрөөний цэвэрлэгээг 18.7 минутад цэвэрлэж байна.

Нэг үйлчлэгч үндсэн ажлын хүрээнд (нэмэлт ажил ороогүй болно) өдөр 9 өрөө цэвэрлэхдээ дунджаар 43.5 минут зарцуулдаг гэж үзвэл өдөрт цэвэрлэгээний ажилд 391.5 минут буюу 6.5 цагийг цэвэрлэгээнд зарцуулж байна. Нэмэлтээр ажил, үүрэг даалгавар авах бол дунджаар 152.2 минут буюу 2.5 цаг нэмэгдэхээр байна. Судалгаанд хамрагдсан үйлчлэгчдийн хувьд ажлын хэт их ачаалалтай байгааг нь тухайн судалгааны үр дүнгээс харж болохоор байна. Албан тасалгааны үйлчлэгч, цэвэрлэгчид нь нийт 14 үндсэн үйл ажиллагааг тогтмол давтамжтайгаар хийж гүйцэтгэдэг байна.

Хүснэгт 5. Нэг өрөөний цэвэрлэгээнд зарцуулж байгаа дундаж хугацаа, ажилбарын ерөнхий ангиллаар, тухайн ажилбарт ажилласан үйлчлэгчдийн тоо

Үзүүлэлт	Ажилласан үйлчлэгчийн тоо		Дундаж хугацаа	
	Тоо	Эзлэх хувь	Секунд	Минут
<b>Дундаж</b>	<b>41</b>	<b>100</b>	<b>2611.3</b>	<b>43.5</b>
1. Бэлтгэл ажил	41	100.	906.4	15.1
2. Цэвэрлэгээг эхлэх, агааржуулалт хийх явц	22	53.7	181.7	3.0
3. Цэцэг арчилгаа	19	46.3	362.9	6.0
4. Ширээ /систем тавилга/, компьютерын цэвэрлэгээ	29	70.7	456.1	7.6
5. Сейф, шүүгээ, номын тавиур, зураг, сувинерын цэвэрлэгээ	25	61.0	451.8	7.5
6. Шилэн гадаргуутай эд зүйлсийн цэвэрлэгээ	25	61.0	380.9	6.3
7. Хог шүүрдэх, тоос соруулах	31	75.6	388.4	6.5
8. Шал угаах	35	85.4	946.6	15.8
9. Хивс цэвэрлэгээ хийх	9	22.0	824.1	13.7
10. Ариун цэврийн өрөө цэвэрлэх	28	68.3	1120.2	18.7
11. Гадна цэвэрлэгээ	10	24.4	1251.9	20.9
12. Коридорын цэвэрлэгээ	27	65.9	3209.3	53.5
13. Шатны цэвэрлэгээ	18	43.9	1690.0	28.2
14. Лифтний цэвэрлэгээ	1	2.4	3120.0	52.0
<b>Нэмэлт ажил</b>	<b>27</b>	<b>65.9</b>	<b>9133.6</b>	<b>152.2</b>

Нэг үйлчлэгч дунджаар өдөрт 9 ажлын өрөө цэвэрлэж байгаа бөгөөд агааржуулалтыг дунджаар 7 өрөөнд, цэцэг арчилгааг 4 өрөөнд, ширээ, компьютерын цэвэрлэгээг 6 өрөөнд,

Сейф, шүүгээ, номын тавиур, зураг, сувинерын цэвэрлэгээг 5 өрөөнд, шал угаах ажилбарыг 7 өрөөнд, Хог шүүрдэх, тоос соруулах ажилбарын 6 өрөөнд тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 6. Нэг өрөөний цэвэрлэгээнд гүйцэтгэсэн ажилбарын давтамж, ерөнхий ангиллаар, тухайн ажилбарыг гүйцэтгэсэн өрөө болон ажилласан үйлчлэгчдийн тоо

Үзүүлэлт	Өрөө			Давтамж		
	Тоо	Злэх хувь	Нэг үйлчлэгч ногдох	Удаа	Өрөөний тоо	Ажилбар хийсэн үйлчлэгч
<b>Дундаж</b>	<b>231</b>	<b>100</b>	<b>9</b>	<b>=</b>	<b>=</b>	<b>=</b>
1. Цэвэрлэгээг эхлэх, агааржуулалт хийх явц	164	71.0	7	2	5	1
2. Цэцэг арчилгаа	67	29.0	4	2	12	2
3. Ширээ /систем тавилга/, компьютерын цэвэрлэгээ	165	71.4	6	2-3	5	2
4. Сейф, шүүгээ, номын тавиур, зураг, сувинерын цэвэрлэгээ	123	53.2	5	=	=	=
5. Шилэн гадаргуутай эд зүйлсийн цэвэрлэгээ	112	48.5	4	=	=	=
6. Хог шүүрдэх, тоос соруулах	193	83.5	6	=	=	=
7. Шал угаах	230	99.6	7	=	=	=
8. Хивс цэвэрлэгээ хийх	21	9.1	2	=	=	=
9. Ариун цэврийн өрөө цэвэрлэх	150	64.9	5	2-4	64	13
10. Коридорын цэвэрлэгээ	73	31.6	3	=	=	=
11. Шатны цэвэрлэгээ	92	39.8	5	=	=	=
12. Лифтний цэвэрлэгээ	1	0.4	1	=	=	=

Тухайн судалгааны мэдээлэл цуглуулах хугацаа нь дулааны улиралд гүйцэтгэгдсэн болохоор давтагдах ажилбарын тохиолдол бага гарсан байна.


*Албан тасалгааны цэвэрлэгч, үйлчлэгчтэй хийсэн ярилцлагаас:*

*Зуны улиралд ажлын ачаалал бага байдаг учир нь сургуулийн хүүхдүүд, албан хаагчид зуны амралтаа авсан байдаг. Харин өвлийн улиралд ачаалал эрс нэмэгддэг. Мөн зарим үед үүдний жижүүр, харуул хамгаалалтын ажилтан давхар хийх буюу өглөө байгууллага онгойлгож, орой тарахад хааж явдаг нь хүндрэлтэй байдаг*

## 2.4 Үйлчлэгчийн ажилд зарцуулж буй хугацаа

Судалгаанд хамрагдсан үйлчлэгч нар бэлтгэл ажилд дунджаар 15.1 минутыг зарцуулж байна. Бэлтгэл ажлын дундаж хугацааг ажилбар бүрээр авч үзвэл цагаа бүртгүүлж, өрөөнд орох, ажил дуусаад цаг бүртгүүлэхэд 2.2 минут, ажлын хувцас сольж өмсөхөд 7.3 минут, гараа угаахад 1.9 минут, шингэн зүйл уухад 5.8 минут, бусад үйл ажиллагаанд 0.8 минутыг тус тус зарцуулж байна.


Зураг 9. Бэлтгэл ажилд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, минут



Судалгаанд хамрагдсан үйлчлэгч нарын 22 (53.7 хувь) нь цэвэрлэгээг эхлэхийн өмнөх агааржуулалт хийх явцыг гүйцэтгэсэн байна. Албан тасалгааны цэвэрлэгч, үйлчлэгчдийн гүйцэтгэж буй ажилбараар авч үзвэл 36.6 хувь нь цэвэрлэгээний багаж хэрэгсэл болох хувин, алчуур болон бусад шаардлагатай хэрэглэлийг зөв, оновчтой дэс дараалалд байршуулсан, 24.4 хувь нь цонхны салхивчийг онгойлгож өрөөний агаар сэлгэх, хаах, 12.2 хувь нь өрөөн доторхыг ажиглах үйлдлийг гүйцэтгэсэн байна.

Цэвэрлэгээг эхлэхийн өмнө агааржуулалтыг нийт 164 (нийт өрөөний 51.1 хувь) өрөөнд хийсэн бөгөөд үйлчлэгч нар дунджаар 181.7 секундийг зарцуулсан байна. Цэвэрлэгээг эхлэх, агааржуулалт хийх явцын дундаж хугацааг ажилбар бүрээр авч үзвэл бэлтгэл (цэвэрлэгээний багаж хэрэгсэл болох хувин, алчуур болон бусад шаардлагатай хэрэглэлийг зөв, оновчтой дэс дараалалд байршуулах) ажилд 108.8 секунд, цэвэрлэх өрөөнд ороход 43.7 секунд, цонхны салхивчийг онгойлгож өрөөний агаар сэлгэх, хаахад 32.6 секунд, өрөөний доторх хэсгийг ажиглахад 11.9 секундийг зарцуулдаг байна.

Зураг 10. Цэвэрлэгээ эхлэх, агааржуулалт хийхэд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр




Судалгаанд хамрагдсан үйлчлэгч нарын 19 (46.3 хувь) нь цэцэг арчилгааг ажлын явцдаа хийсэн байна. Цэцэг арчилгааг хийсэн үйлчлэгч нар нийт 67 (нийт өрөөний 20.9 хувь) өрөөний 326 цэцэгт арчилгаа хийсэн бөгөөд нэг өрөөний цэцэг арчилгаанд дунджаар 362.9 секундийг зарцуулсан байна.

Нэг өрөөний цэцэг арчилгаанд зарцуулсан дундаж хугацааг зарим ажилбараар авч үзэхэд 168.3 секундийг цэвэрлэгээний бодис тааруулахад, 106.9 секундийг цэцэг услахад, 67.9 секундийг цэцэг арчлах, 49.7 секундийг бохир алчуурыг угаахад зарцуулсан байна.



Зураг 11. Цэцэг арчилгаанд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр



Судалгаанд хамрагдсан үйлчлэгч нарын 29 (70.7 хувь) нь ширээ /систем тавилга/, компьютерын цэвэрлэгээ хийсэн байна. Ширээ /систем тавилга/, компьютерын цэвэрлэгээ хийсэн үйлчлэгч нар 165 (нийт өрөөний 51.4 хувь) өрөөний 677 ширээ /систем тавилга/, компьютерын цэвэрлэгээг хийсэн. Нэг өрөөний ширээ /систем тавилга/, компьютерын цэвэрлэгээнд дунджаар 456.1 секундийг зарцуулсан байна. Нэг өрөөний ширээ /систем тавилга/, компьютерын цэвэрлэгээнд зарцуулсан дундаж хугацааг зарим ажилбараар авч үзэхэд 282.5 секундийг ширээ, компьютерын цэвэрлэгээнд, 76.5 секундийг хувинд цэвэр ус хийхэд, 58.9 секундийг бохир алчуураа угаахад, мушгих, 46.2 секундийг бохир усаа асгахад зарцуулсан байна.

Зураг 12. Ширээ /систем тавилга/, компьютерийн цэвэрлэгээнд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр



Судалгаанд хамрагдсан үйлчлэгч нарын 25 (61.0 хувь) нь сейф, шүүгээ, номын тавиур, зураг, сувинерын цэвэрлэгээ хийсэн байна. Сейф, шүүгээ, номын тавиур, зураг, сувинерын цэвэрлэгээ хийсэн үйлчлэгч нар 123 (нийт өрөөний 51.4 хувь) өрөөний 965 сейф, шүүгээ, номын тавиур, зураг, сувинерын цэвэрлэгээ хийсэн. Нэг өрөөний сейф, шүүгээ, номын тавиур, зураг, сувинерын цэвэрлэгээнд дунджаар 451.8 секундийг зарцуулсан байна. Нийт цэвэрлэсэн сейф, шүүгээ, номын тавиур, зураг, сувинерын 48.8 хувь нь шүүгээ, 12.2 хувь нь номын тавиур, 11.2 хувь нь буйдан, 9.3 хувь нь хаалга, 7.4 хувь нь сувинер байна.

Зураг 13. Сейф, шүүгээ, номын тавиур, зураг, сувинерын цэвэрлэгээ, төрөл, хувиар




Нэг өрөөний сейф, шүүгээ, номын тавиур, зураг, сувинерын цэвэрлэгээнд зарцуулсан дундаж хугацааг ажилбар бүрээр авч үзэхэд сейф цэвэрлэгээнд 67.6 секунд, шүүгээ цэвэрлэгээнд 233.4 секунд, номын тавиур цэвэрлэгээнд 156.3 секунд, ханын цэвэрлэгээнд 292.8 секунд, сувинер цэвэрлэгээнд 85.2 секунд, хаалга болон хаалганы бариулын цэвэрлэгээнд 95.6 секунд, радиаторын хэсгийн цэвэрлэгээнд 225.0 секунд, буйдан, сандал цэвэрлэгээнд 223.1 секундийг зарцуулж байна.

Зураг 14. Сейф, шүүгээ, номын тавиур, зураг, сувинерын цэвэрлэгээнд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр




Судалгаанд хамрагдсан үйлчлэгч нарын 25 (61.0 хувь) нь 112 (нийт өрөөний 34.9 хувь) өрөөний нь 404 шилэн гадаргуутай эд зүйлсийн цэвэрлэгээг хийсэн байна. Нэг өрөөний шилэн гадаргуутай эд зүйлсийг цэвэрлэхэд дунджаар 380.9 секундийг зарцуулсан. Цэвэрлэсэн шилэн гадаргуутай эд зүйлсийн 18.8 хувь нь толь, 57.2 хувь нь цонх, 23.8 шилэн тусгаарлагч байна. Цэвэрлэгээнд зарцуулсан дундаж хугацааг зарим ажилбараар авч үзэхэд шилэн тусгаарлагчийг цэвэрлэхэд 785.5 секунд, цонх цэвэрлэгээнд 263.7 секунд, толь цэвэрлэгээнд 93.9 секунд, цэвэрлэгээний хэрэгслийг бэлэн болгоход 272.8 секундийг зарцуулж байна.

Зураг 15. Шилэн гадаргуутай эд зүйлсийн цэвэрлэгээнд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр



Судалгаанд хамрагдсан үйлчлэгч нарын 31 (75.6 хувь) нь хог шүүрдэх, тоос соруулах цэвэрлэгээний ажил хийж гүйцэтгэсэн байна. Хог шүүрдэх, тоос соруулах цэвэрлэгээ хийсэн үйлчлэгч нар 193 (нийт өрөөний 60.1 хувь) өрөөний хог шүүрдэж, тоос соруулсан байна. Нэг өрөөний хог шүүрдэх, тоос соруулах ажилбарт дунджаар 388.4 секундийг зарцуулсан бөгөөд дундаж хугацааг зарим ажилбараар авч үзвэл хог шүүрдэхэд дунджаар 204.7 секунд, цуглуулсан хогийг гаргаж хаяхад 290.8 секунд, тоос соруулахад 771.9 секунд тус тус зарцуулсан байна.


Зураг 16. Хог шүүрдэх, тоос соруулах цэвэрлэгээнд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр



Нийт үйлчлэгч, цэвэрлэгч нарын 35 (85.4 хувь) нь шал угаасан бөгөөд 230 (нийт өрөөний 71.7 хувь) өрөөний шал угааж цэвэрлэсэн байна. Нэг өрөөний шал угаах ажилбарт дунджаар 946.6 секундийг зарцуулсан байна.

Шал угаах цэвэрлэгээнд зарцуулсан дундаж хугацааг зарим ажилбараар авч үзэхэд шал арчихад дунджаар 587.8 секунд, шал угаагчид ус хийхэд 119.4 секунд, шал угаагчид шалны даавууг хийж угаах, мушгихад 109.8 секунд, бохир алчуурыг угааж мушгихад 110.5 секундийг тус тус зарцуулсан байна.


Зураг 17. Шал угаах ажилбарт зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр



Судалгаанд хамрагдсан үйлчлэгч нарын 9 (22.0 хувь) нь хивс цэвэрлэгээ хийсэн бөгөөд 21 (нийт өрөөний 13.7 хувь) өрөөний 25 ширхэг хивсийг угааж цэвэрлэсэн байна. Нэг өрөөний хивс цэвэрлэх ажилбарт дунджаар 824.1 секундийг зарцуулсан байна.

Хивс цэвэрлэгээнд зарцуулсан дундаж хугацааг зарим ажилбараар авч үзэхэд хивс угаахад дунджаар 638.0 секунд, хивс угаагчийн бохирыг асгах, цэвэрлэхэд 134.0 секунд тус тус зарцуулсан байна.


Зураг 18. Хивс цэвэрлэгээ хийхэд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр



Судалгаанд хамрагдсан үйлчлэгч нарын 28 (68.3 хувь) нь ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ хийсэн бөгөөд 150 өрөөний суултуур, бясаагуур, угаалтуур, гар хатаагч цэвэрлэх, шал угаах, ариутгал хийж нянгүйжүүлэх ажилбар хийсэн байна. Нэг ариун цэврийн өрөөг цэвэрлэх ажилбарт дунджаар 1120.2 секунд буюу 18.7 минутыг зарцуулдаг байна. Ариун цэврийн өрөөний 472 хэрэгслийг цэвэрлэсэн байна.

Ариун цэврийн өрөө цэвэрлэсэн нэг үйлчлэгчид дунджаар 5 өрөө ноогдож байгаа бөгөөд хэрэгслээр авч үзвэл 7 суултуур, 2 бясаагуур, 5 угаалтуур, 2 гар хатаагч ноогдож байна.

Зураг 19. Ариун цэврийн өрөөний тоо, нэг үйлчлэгчид ноогдох дундаж, хэрэгсэлээр



Нэг ариун цэврийн өрөөг цэвэрлэхэд зарцуулсан дундаж хугацааг зарим ажилбар бүрээр авч үзэхэд угаалтуур цэвэрлэхэд дунджаар 164.8 секунд, суултуур, болон холбогдох эд зүйлсийг цэвэрлэхэд 263.2 секунд, шал угаахад 196.8 секунд, ариутгал хийж нянгүйжүүлэхэд 90.3 секунд, хогийн савны хог хаягдлыг цуглуулах, хогны уут шинээр хийхэд 122.9 секунд зарцуулсан байна.

Нийт ариун цэврийн өрөөний 94.0 хувьд нь угаалтуур угаах, 93.3 хувьд нь шал угаах, 89.3 хувь нь суултуур, болон холбогдох эд зүйлсийг цэвэрлэх, 41.3 хувьд нь ариутгал хийж нянгүйжүүлэх ажилбар хийгдсэн байна.

Ариун цэврийн өрөөний цэвэрлэгч үйлчлэгчтэй хийсэн ярилцлагаас :


Зөвхөн байгууллагын албан хаагчид үйлчлүүлэхээс гадна иргэд үйлчлүүлдэг. Маш бохир нөхцөлд ажилладаг болохоор амьсгалын замын өвчлөл, уушгины архаг өвчтэй гэсэн оноштой байгаа. Цалин дээр 5%-ын сүү, тарганы нэмэгдэл өгдөг. Бидний нөхцөлийг судалж үзээд хортой нөхцөлд оруулах саналтай байна

Зураг 20. Ариун цэврийн өрөө цэвэрлээнд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр




Судалгаанд хамрагдсан үйлчлэгч нарын 10 (24.4 хувь) нь гадна талбайн цэвэрлэгээг хийсэн дунджаар 1251.9 секунд буюу 20.9 минутыг зарцуулсан байна. Гадна талбайн цэвэрлэхэд зарцуулсан дундаж хугацааг ажилбараар авч үзэхэд хаалганы дотор, гадна байрлах үүдний хөлийн гишгүүрийг цэвэрлэж байрлуулахад 370.0 секунд, хөдөлмөрлөх явцад сул үйлдэл, хөдөлгөөн гаргахгүйгээр зөв байрлуулах, оновчтой дэс дараалалд оруулахад 60.7 секундийг зарцуулж байна.

Зураг 21. Гадна талбайн цэвэрлээнд зарцуулсан дундаж хугацаа, ажилбараар, секундээр



Судалгаанд хамрагдсан үйлчлэгч нарын 27 (65.9 хувь) нь коридорын цэвэрлэгээ, 18 (43.8 хувь) нь шатны цэвэрлэгээ, 1 (2.4 хувь) нь лифтний цэвэрлэгээ хийсэн байна. Нэг үйлчлэгч коридорын цэвэрлэгээ хийхэд дунджаар 53.5 минут, шатны цэвэрлэгээ хийхэд дунджаар 28.2 минут, лифтний цэвэрлэгээ хийхэд дунджаар 52.0 минут зарцуулж байна.

Зураг 22. Коридор, шатны тоо, цэвэрлэх талбай, дундаж хугацаагаар



## БҮЛЭГ ГУРАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

### ДҮГНЭЛТ

Албан байгууллагын буюу оффисын цэвэрлэгч /үйлчлэгч/-ийн ажлын цаг ашиглалт, хөдөлмөр зарцуулалтын норматив хэмжээг судлан, ажлын ачааллыг тооцох зорилгоор 29 байгууллагын 41 үйлчлэгчийн ажлын байранд зураглал хийж, 29 хүний нөөц удирдах албан тушаалтнаас асуумж авч, судалгааны гарсан үр дүнгүүдээс дараах дүгнэлтийг хийж байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын улсын хяналтын албаны даргын 2001 оны "Нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбай, ажлын үлгэрчилсэн хэмжээ" 03 тоот тушаалаар батлагдсан журмыг 22 жил мөрдөж байна. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 03 дугаар тогтоолоор "Хөдөлмөрийн норм, норматив боловсруулах аргачлал" батлагдсан. Гэвч судалгаанд хамрагдсан байгууллагуудын 65.5 хувь нь байгууллагад ажлын байрны норм, норматив байхгүй, 69.0 хувь нь үйлчлэгч/цэвэрлэгч/-ийн ажлын байрны ачааллыг тооцож байгаагүй, 62.1 хувь нь үйлчлэгчийн ажлын байрны стандартгүй гэж хариулсан байна. үйлчлэгчийн ажлын байрны стандартгүй гэж хариулсан нь аж ахуйн нэгж байгууллагууд үйлчлэгчийн норм, норматив, ажлын байрны ачааллын талаар мэдээлэлгүй байгаа нь харагдаж байна. Иймд нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбай, ажлын үлгэрчилсэн хэмжээг зайлшгүй шинэчилж, стандартыг мөрдүүлэх шаардлагатай болсныг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан үйлчлэгч нарыг ажилласан хугацааг сараар авч үзвэл 46.4 хувь нь 1-6 сар ажилласан, 4 байгууллага тутмын нэг (27.6 хувь) нь сул орон тоотой байна. Үйлчлэгчийн сул орон тоо нэлээдгүй их байгаа нь Хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгааны ажиллах хүчний эрэлттэй ажил мэргэжилтэй нийцэж байна.

Нэг үйлчлэгч үндсэн ажлын хүрээнд (нэмэлт ажил ороогүй болно) өдөр дунджаар 391.5 минут буюу 6.5 цагийг цэвэрлэгээнд зарцуулж байна. Нэмэлтээр ажил орж ирвэл дунджаар 152.2 минут буюу 2.5 цаг нэмэгдэхээр байна. Энэ нь албан тасалгааны үйлчлэг нарийн хувьд ажлын хэт их ачаалалтай байгаа нь илэрхийлж байна.

Судалгаанд хамрагдсан үйлчлэгч нарын сарын дундаж үндсэн цалин улсын хэмжээний нийт дундаж цалингаас бага буюу 699.5 мянган төгрөг байгаа болон 2 үйлчлэгч тутмын нэг нь 1-4 цаг илүү цагаар ажилладаг нь тухайн ажлын байран дах ажиллах хүчний хомсдол үүсэх үндсэн нөхцөл болж байна.

Үйлчлэгчдийн 90.8 хувь нь ажлын өрөө болон ариун цэврийн өрөөг хамтад нь цэвэрлэдэг. Эндээс үзэхэд ажлын өрөө, ариун цэврийн өрөөний үйлчлэгчийг тус тусад нь байлгаснаар албан хаагчдын ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад нийцэх, мөн үйлчлэгчдийн ачаалал багасах боломжтой гэж дүгнэж байна.

Судалгаанд хамрагдсан байгууллагуудын үйлчлэгчдийн 58.6 хувь нь улирлын чанартай ачаалал нэмэгддэг ба улирлын өөрчлөлтөд тохируулан үйлчлэгчийн орон тоог нэмж, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх боломжтой харагдаж байна



## ЗӨВЛӨМЖ

Цэвэрлэгч /үйлчлэгч/-ийн ажлын байрны сул орон тоог багасгах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах. Нөлөөлж буй хүчин зүйл буюу үндсэн цалинг нэмэгдүүлэх, урамшуулал, илүү цагийн нэмэгдлийг тооцох.

Бүтэц, орон тоог батлахдаа “Нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбай, ажлын үлгэрчилсэн хэмжээ” болон стандартад нийцүүлэн нэг байгууллагын нийт м<sup>2</sup>-ыг үйлчлэгч /цэвэрлэгч/-ийн цэвэрлэх талбайд харгалзуулж, орон тоог батлах. Ингэснээр ажлын ачаалал багасаж, тогтвор суурьшилтай ажиллах боломж бүрдэнэ. Мөн тухайн байгууллагын нийт м<sup>2</sup>-ыг тооцож, ажлын өрөө болон ариун цэврийн өрөөний үйлчлэгчдийн орон тоог тус тусад нь баталж өгөх

Үйлчлэгчийн ажил нь улирлын чанартай ажлын ачаалал нэмэгдэж байгаа тул улирлаас шалтгаалж үйлчлэгчийн орон тоог нэмэх зохицуулалтыг хийж байх